

**“ХӨВСГӨЛ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

25/02

Огноо	2025 оны 9 сарын 22
Цаг	15:00
Хурал хаасан цаг	16:30
Хурал хуралдуулах газар /хаяг, байршил/	Цахим-Ард апп
Хурал зарлагч	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурлын дарга	Ч.Ганхуяг
Хуралд оролцсон	Хурал зохион байгуулах комисс, Хурлын дарга, ТУЗ-ийн дарга, Тооллогын комиссын гишүүд, Хувьцаа эзэмшигчид
“Хөвсгөл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг энэхүү хурлын дэгийн дагуу 15:00 цагт нээв.	

:

ХУРЛЫГ НЭЭСЭН НЬ:

Ч.Ганхуяг: Өдрийн мэнд, Эрхэм Хувьцаа эзэмшигчдээ “Хөвсгөл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцож буй та бүхэнд талархал илэрхийлье. Хурлыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 25/08 дугаартай тогтоолын дагуу Хурлын даргаар Ч.Ганхуяг би даргалахаар сонгогдсон. Иймд та бүхэнд өнөөдрийн хурлын дэгийг танилцуулъя. (хурлын дэгийг танилцуулав.) Ингээд хурлын дэгийн дагуу 2025 оны 09 сарын 22-ны өдрийн хурлын ирцийн талаар мэдээлэхийг тооллогын комиссын бүрэлдэхүүнээс хүсэж байна.

Тооллогын комиссийн дарга Ө.Бямбагэрэл: Өнөөдрийн “Хөвсгөл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн тухай танилцуулъя. Компанийн нийт гаргасан саналын эрхтэй нийт 86,707,294 ширхэг хувьцаанаас 67,157,415 ширхэг буюу 82.5 хувийн ирцтэйгээр хурал хүчин төгөлдөр болохыг мэдэгдэв.

Ч.Ганхуяг: Энэхүү хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулав. ХЭХ-ийн материалыг хувьцаа эзэмшигчдэд БДК-аар дамжуулан илгээж, холбогдох журамд заасны дагуу танилцах нөхцөл боломжоор хангасан тул уншиж танилцсан байгаа гэдэгт итгэлтэй байна. Иймд хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудал тус бүрээр холбогдох танилцуулгыг хийж танилцуулъя.

Ч.Ганхуяг: “Хөвсгөл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг танилцуулж, цаашид хийгдэх төлөвлөгөө, компанийн бүтцийн талаар танилцуулав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хэлэлцэх асуудал №1,2,3 Компанийн оноосон нэрийг “Хөвсгөл” байсныг “Ард Инвестмент Групп” болгон өөрчлөх, Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, Компанийн хувьцааны бүртгэлтэй байгаа биржийг Монголын Хөрөнгийн Биржээс Улаанбаатар Үнэт Цаасны Бирж болгон өөрчлөх тухай хэлэлцэн батлах

Ч.Ганхуяг: Хэлэлцэх асуудал №1 Компанийн оноосон нэрийг “Хөвсгөл” байсныг “Ард Инвестмент Групп” болгон өөрчлөх талаар танилцуулж, дүрмийн өөрчлөлтийн төсөлийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Ч.Ганхуяг: Хэлэлцэх асуудал №2 Компанийн нэрийг өөрчлөхтэй холбоотойгоор хийгдэх дүрмийн өөрчлөлтийн төслийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Ч.Ганхуяг: Хэлэлцэх асуудал №3 Компанийн хувьцааны бүртгэлтэй байгаа биржийг Монголын Хөрөнгийн Биржээс Улаанбаатар Үнэт Цаасны Бирж өөрчлөхтэй холбоотойгоор Улаанбаатар Үнэт цаасны Биржийн танилцуулгыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

АСУУЛТ, ХАРИУЛТ

Байхгүй.

САНАЛ ХУРААЛТ

Тооллогын комисс Хурлаар хэлэлцсэн саналын дүнг танилцуулав:

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дахь заалтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал болон хурлын үеэр өгсөн саналыг тус тус тоолж, санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хурлаар хэлэлцсэн Компанийн оноосон нэрийг “Хөвсгөл” байсныг “Ард Инвестмент Групп” болгон өөрчлөх асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 67,157,415 ширхэг буюу 82.5 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - Зөвшөөрсөн: 67,157,415 ширхэг буюу 100%
 - Татгалзсан: байхгүй
 - Түдгэлзсэн: байхгүй байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
2. Хурлаар хэлэлцсэн Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 67,157,415 ширхэг буюу 82.5 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - Зөвшөөрсөн: 67,157,415 ширхэг буюу 100%
 - Татгалзсан: байхгүй
 - Түдгэлзсэн: байхгүй байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
3. Хурлаар хэлэлцсэн Компанийн хувьцааны бүртгэлтэй байгаа биржийг Монголын Хөрөнгийн Биржээс Улаанбаатар Үнэт Цаасны Бирж болгон өөрчлөх асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 67,157,415 ширхэг буюу 82.5 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - Зөвшөөрсөн: 67,157,415 ширхэг буюу 100%
 - Татгалзсан: байхгүй
 - Түдгэлзсэн: байхгүй байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Ч.Ганхуяг: Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулсан тул 2025 оны 09 сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарах шийдвэрийг танилцуулъя. Дараах шийдвэрүүдийг уншиж танилцуулав. 1.Компанийн оноосон нэрийг “Хөвсгөл” байсныг “Ард Инвестмент Групп” болгон өөрчлөх тухай, 2.Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай, 3.Компанийн хувьцааны бүртгэлтэй байгаа биржийг Монголын Хөрөнгийн Биржээс Улаанбаатар Үнэт Цаасны Бирж болгон өөрчлөх тухай асуудлууд тус дэмжигдэж шийдвэрлэгдлээ.

ХУРЛЫН ХААЛТ:

Ч.Ганхуяг: Үүгээр өнөөдрийн хурал өндөрлөснийг мэдэгдье. Хурлыг зохион байгуулсан ажлын хэсэг болон тооллогын комиссын бүрэлдэхүүнд баярлалаа. Хурал хаалаа.

ХЯНАСАН,
ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Ч.ГАНХУЯГ

Э.ХАЛИУНГОО